

**“ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТУХАЙ”  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААР БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 01 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

Улсын Их Хурлын нэр бүхий 9 гишүүнээс Улсын Их Хуралд 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн “Хөгжлийн бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг чуулганы нэгдсэн хуралдааны 2014 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар шийдвэрлэж төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороодод шилжүүлсний дагуу Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2014 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Хэлэлцүүлгийн явцад салбарын бодлоготой холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд дараах саналыг гаргасан болно. Үүнд:

1.Улсын Их Хурлын гишүүн А.Бакей “салбарын бодлогод дүн шинжилгээ хийж, өнөөгийн нөхцөл байдалд зохицуулан өөрчлөх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг гүн боловсруулах үйлдвэр байгуулах, бүтээгдэхүүн боловсруулалтыг нэмэгдүүлэх, өвөлжөө, хаваржааны доорх газрыг малчин өрхөд эзэмшүүлэх, малчдын бүлэгт бэлчээр эзэмшүүлэх, ашиглуулах, хоршоо, нөхөрлөл байгуулах замаар малчид хамтран ажиллаж, бизнесээ хөгжүүлэх орчинг бүрдүүлэх, газар тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих, улаан буудайн импорт, экспортын судалгаа хийж, бодлогодоо тусгах нь зүйтэй” гэсэн саналыг;

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат “Монгол мал хөтөлбөрт концепцийн шинэ өөрчлөлт хийж, малын ашиг шимийн орлогоос малчдын амьжиргаа дээшилж, орлого нэмэгдэж байх бодлогыг тусгах нь зүйтэй. Урамшуулалаас гадна төр болон малчдын харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, орон нутгийн хөгжил, малчдын орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлдвэрлэлийн бодлогыг бүсчилж явуулах, тухайлбал, газар тариалан, бэлчээрийн мал ахуйн бүсийг тодорхой болгох, хүн ам ихтэй суманд ноос, ноолуур, мах, сүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх төрийн бодлого явуулах нь зүйтэй гэсэн саналыг;

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатар салбарын бодлогыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах, өвөлжөө, хаваржааны бэлчээрийн асуудлыг бодлогоор нилээд нухацтай ярих хэрэгтэй гэсэн саналыг;

4.Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл “хөнгөн үйлдвэрийн салбарт газар зүйн заалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэх томоохон зорилт тавьж ажиллах нь зүйтэй” гэсэн саналыг;

5. Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогод бид анхаарлаа хандуулж ажиллана, ялангуяа, байгаль цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон, олон улсын зах зээлийн эрэлт, хэрэгцээ шаардлагад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг бүсчлэн, уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг зонхилон хөгжүүлэх бодлого, хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх нь зүйтэй” гэсэн саналыг тус тус гаргасан болно.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж, түүнийг боловсронгуй болгох санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах нь зүйтэй гэж үзэв.

“Хөгжлийн бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

“Хөгжлийн бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлж байна.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ  
АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА**



**Г.БАЯРСАЙХАН**